

ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.06.10

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
<b>1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ</b>								
<b>Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын бүлгүүдийн хөгжил, оролцоог хангах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн салбар дундын гэр бүлд ээлтэй цогц бодлого боловсруулж, хүн амын тогтвортой өсөлт, гэр бүл, хүний хөгжлийг дэмжих стратегийн зорилт 2.4.3-ын хүрээнд:</b>								
<b>Зорилт 1: Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах</b>								
1.1	Арга хэмжээ 1.1. Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.  /ЗГҮАХ 2024-2028-2.1.1.2/	Улсын төсөв 52.0 сая.төг	Боловсруулсан үзэл баримтлал /тоо/	0	1	1	Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2025.01.31-ны өдөр хамтран баталсан.	100
			Хуулийн төсөл /тоо/	0	1	1	Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл-1, Дагалдан боловсруулсан хуулийн төслийн тоо -5	
			Хэлэлцүүлэг /тоо/	0	10	10	Хуулиар эрх ашиг нь хөндөгдөх бүлгүүд, иргэдийн төлөөлөл, төр, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөллөөр хэлэлцүүлсэн 13 хэлэлцүүлгийн тайлан гаргасан.	
			Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/	0	1	1	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл боловсруулж хүргүүлсэн. Нийт 13 төрлийн бичиг баримтыг боловсруулсан.  2025.06.03-ны өдрийн 01/1843 тоот албан бичгээр ЗГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2025.06.04-ний өдрийн 26 дугаар хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.	

1.2	Арга хэмжээ 1.2. "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 2024-2028-2.1.1.2/	Улсын төсөв	Боловсан хөтөлбөр /тоо/;	0	0	1	Хугацаа болоогүй, II дахь хагас жил боловсруулахаар төлөвлөсөн. ХГБХХЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулсны дагуу тус газар ажлын хэсгийн байгуулсан.	Х/б
<b>Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох</b>								
2.1	Арга хэмжээ 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /Алсын хараа 2050-2.3.3/	Улсын төсөв	Хуулийн төсөл /тоо/	0	-	1	ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 3 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан. Мөн дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл боловсруулах ажлын явц 70 хувьтай байна.	90
			Дагалдан гарах хуулийн төсөл /тоо/	0	-	1		
			Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/	0	-	1		
2.2	Арга хэмжээ 2.2. Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн болон түүнийг нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /Алсын хараа 2050 2.3.3, ЗГҮАХ 2024-2028 -2.5.8/	Улсын төсөв	Хуулийн төсөл /тоо/	0	-	1	ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан. Мөн дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл боловсруулах ажлын явц 60 хувьтай байна.	90
			Дагалдан гарах хуулийн төсөл /тоо/	0	-	1		
			Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/	0	-	1		
2.3	Арга хэмжээ 2.3. Дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулна.	Улсын төсөв	Хуулийн төсөл /тоо/	0	-	1	3 дугаар хавсралтаар Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийг хуралд оролцогчдын саналыг тусган хянан сайжруулж байна. Мөн ажлын хэсэг "Монгол дохионы хэл ба хөгжлийн чиг хандлага" хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар 28-ны өдөр	90
			Үзэл баримтлалын төсөл /тоо/	0	-	1		

							Боловсролын яам болон харьяа байгууллагууд, СЗСҮТ, МБУЧОС, МУСИҮХ, Сонсголгүйн боловсрол, Тэгш тусгал ТББ-дын төлөөлөл, Олон улсын хөгжлийн болон донор байгууллагын төлөөлөлтэй хамтран зохион байгуулсан. Мөн “Сонсголгүйн боловсрол” ТББ, Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоотой хамтран “Эрт үеийн оролцоо ба сонсголгүйн боловсрол” хэлэлцүүлгийг 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, хуулийн төслийг хэлэлцүүлсэн. Хуулийн төсөл боловсруулах ажлын явц 50 хувьтай байна.	
<b>Зорилт 3: Хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангах</b>								
3.1	Арга хэмжээ 3.1. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулж, хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээ нэвтрүүлнэ.  /ЗГҮАХ 2024-2028-2.1.1.4, 2.1.1.13, 2.1.1.15, 2.1.1.18/	Улсын төсөв	Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн заавар, зөвлөмж /тоо/	0	1	1	1 Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн заавар, зөвлөмжийг ГБХНХСайдын 2025.04.16-ны А/92 тушаалаар батлуулсан. ХГБХХЕГ-т хэрэгжилтийг зохион байгуулан орон нутгийн Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх чиглэлийг өгсөн.	90
			Гэр бүлийн хөгжлийн цогц төв /тоо/	0	4	4	Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйлчилгээний загварыг 2 аймаг, 2 сум, 1 дүүрэг (Орхон, Сэлэнгэ аймаг, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Бэрх сум, Сүхбаатар дүүрэг)-т бий болгохоор ажиллаж байна. Мөн туршилтаар БНСУ-д Гэр бүл, хүүхдийн төвийг нээн ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
			Эхчүүд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ /тоо/	0	1	1	Эхчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөн үйлчилгээний зураглал боловсруулж байна. Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр, эдийн засгийн чадавхжуулалт, ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, Хувь хүний хөгжил, чадавхжуулалтын хөтөлбөр, Аюулгүй байдлын хамгаалалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж боловсруулсан зураглал дээр санал авахаар ажиллаж байна. “Асрахуйн эдийн засагт төр ба хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд байнгын асаргаа шаардлагатай гэр бүлийн гишүүдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй	

							байгаа эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх бодлогын хувилбар боловсруулах, замын зураглал гаргах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг ашиглан байнгын асаргааны санхүүжилтын шинэ загвар боловруулахаар төлөвлөж байна.	
			Эрэгтэйчүүд, аавуудад чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ /тоо/	0	1	1	Тайлагнах хугацаа болоогүй.	
			Ахмадуудад чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ /тоо/	0	1	1	Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйлчилгээнд ахмад настанд чиглэсэн хөтөлбөрийн төслийг боловсруулсан.	
3.2	Арга хэмжээ 3.2. Хүн ам зүй, гэр бүл, эмэгтэйчүүдийн асуудлаар Think tank хэлэлцүүлэг зохион байгуулж бодлогын шийдэл гаргана.	ОУБ 74.0 сая.төг	Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо	0	2	4	<p>1/ НҮБХХ-тэй хамтран Асрахуйн эдийн засагт хөрөнгө оруулах нь хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр олон талт оролцогчдын төлөөлөл 70 хүн оролцсон. Хэлэлцүүлгийн үр дүнд НҮБХХ-тэй хамтран асрахуйн эдийн засгийг бэхжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр болсон. Энэ ажлын хүрээнд "Монгол Улсад асрахуйн эдийн засгийг бэхжүүлэх нь" төслийн баримт бичигт санал авахаар бодлогын газруудад дотоод албан бичиг хүргүүлж, ирсэн саналыг нэгтгэн тусгаж 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр ТНБД-д танилцуулсан. Мөн төслийн асуудлаар НҮБХХ-ийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй санал солилцох уулзалтуудыг хэд хэдэн удаа хийсэн.</p> <p>2/ "Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаа" хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 18 –ны өдөр зохион байгуулж, ГБХНХЯ дээр ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон ХЗДХЯ, ЭМЯ, ОУБ, Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл зэрэг 50 хүн оролцсон.</p> <p>3/ Үндэсний шилжүүлгийн дансны хэлэлцүүлгийг 06 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулахтай холбогдуулан НҮБХАС-ын тэргүүн Халид Шариф, мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлгийн үеэр олон улсын зөвлөхүүдээр</p>	90

							илтгэл тавиулахаар 5 үндсэн илтгэлийн сэдвийг тохирсон. Хэлэлцүүлгийг зохион байгуулах бэлтгэл ажил хангаж байна. Өндөр түвшний бодлогын хэлэлцүүлгийн зорилго нь бодлого боловсруулагчид, Засгийн газрын гишүүд, шийдвэр гаргагчид, яамны хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүд, эрүүл мэнд, боловсрол, залуучуудын ажил эрхлэлт, эмэгтэйчүүдийн эрх мэдэлжүүлэлтэд оруулах хөрөнгө оруулалтын стратегийн ач холбогдлыг таниулах, хэлэлцэх явдал юм. Хэлэлцүүлэг нь Үндэсний шилжүүлгийн данс (NTA), Үндэсний хугацааны шилжүүлгийн данс (NTTA)-ын олон улсын туршлага дээр тулгуурласан, Монгол Улсын тогтвортой ирээдүйг хангах өсөлтийн чухал салбаруудад чиглэсэн бодит хөрөнгө оруулалтын зөвлөмжүүдийг онцлох юм.	
3.3	Арга хэмжээ 3.3. Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх хүрээнд E-family платформын хөгжүүлэлтийг эхлүүлнэ. /ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.3/	Улсын төсөв 13.0 сая.төг	Баталсан аргачлал, норматив	0	1	1	1 Гэр бүлийн цэсийн үйлчилгээний загвар жагсаалтыг боловсруулан ЦИӨБГ-т болон <a href="mailto:batzul@emg.gov.mn">batzul@emg.gov.mn</a> хаягаар /2025.04.15/ хүргүүлэв. Ажлын хэсгээс хүссэний дагуу нэмэлтээр түгээмэл, асуулт хариултын жагсаалтыг боловсруулан хүргүүлэхээр ажиллаж байна.	90
			Батлагдсан стандарт /тоо/	0	1	1		
3.4	Арга хэмжээ 3.4. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандарт, санхүүжүүлэх зардлын аргачлал, нормативыг батлан мөрдүүлнэ. /ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.7/	Улсын төсөв 4.9 тэрбум	Аргачлал, норматив /тоо/	0	1	1	Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, зардлын нормативын төслийг боловсруулж, 4 удаа хэлэлцүүлсэн. Холбогдох саналуудыг тусгаж, эцэслэж санал авахаар Боловсролын яам, Сангийн яаманд хүргүүлэхэд бэлдээд байна. 3 сайдын хамтарсан тушаалаар 2025 оны 4 дүгээр улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна.	90
			Стандарт	0	2	2	2025 оны 3 дугаар улиралд багтаан хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчилал техникийн хороонд хүргүүлнэ. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартын төсөлд санал авч нэгтгэсэн. 2025 оны 3	

							дугаар улиралд багтаан Хүүхдийн эрхийн стандартын хороонд хүргүүлж ажиллана.	
			Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд /тоо/	0	0	70000	Давхардсан тоогоор 105776 хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан.	
3.5	Арга хэмжээ 3.5. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын МУЗГ-ын 6,7 дугаар тайланг боловсруулж, НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд хүргүүлнэ. /Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар зөвлөмжийн 49 дүгээр зүйл/	Улсын төсөв 80.0 сая	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/;	0	1	1	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 03/771 дугаар албан бичгээр "Хүүхдийн эрхийн тухай конвенцын Хорооны Нарийн бичгийн дарга нарын газраас 2027 оныг хүртэл Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит 6, 7 дугаар хамтатгасан илтгэлийг хялбаршуулсан журмаар бэлтгэж хүргүүлэх хуваарь хойшилсон"-ыг уламжилсан.	Х/б
<b>2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>								
<b>Зорилт 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах;</b>								
4.1	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зураглалыг боловсруулна.	үйл ажиллагааны зардал	Зураглал /тоо/	0	-	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зураглалыг төрийн бус байгууллагуудын саналд үндэслэн Эрүүл мэндийн яам, Боловсролын яамтай хамтран боловсруулж, төслийг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлд танилцуулсан. Үйлчилгээний зураглалыг Эрүүл мэнд, Боловсрол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан уулзалтад танилцуулахаар бэлтгэж байна.	90
4.2	Арга хэмжээ 4.2. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг туршина. /ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.25/	Улсын төсөв 50.0 сая.төг	Туршилт хийх аймаг, дүүрэг /тоо/	0			Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг зохион байгуулахаар ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд тус судалгааны асуулгад тус аргачлалыг ашиглахаар бэлтгэж байна. Мөн ХБИХЭДТ-д үйлчилгээ авах иргэдийн үнэлгээнд аргачлалыг ашиглахаар туршилтыг хийж эхлээд байна. Мөн Үйл ажиллагааны олон улсын ангилал (ICF)-ыг ашиглаж буй салбаруудын өнөөгийн байдал, цаашдын хамтын ажиллагааны талаарх салбар	70

							дундын уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттай нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, салбар дундын хамтарсан ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөөг ЭМЯ, БоЯ-тай хамтран байгуулж ажиллуулахаар ажлын хэсгийн удирдамжийг боловсруулан ажиллаж байна. Түүнчлэн ХБХЭМБНХСК-ийн хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох үйл ажиллагаанд (ICF)-ыг нэвтрүүлэхээр зөвлөх үйлчилгээний удирдамжийн төслийг боловсруулан сонгон шалгаруулалт зарлахаар бэлтгэж байна.	
4.3	Арга хэмжээ 4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг зарим аймаг, дүүрэгт байгуулна. /ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.26/	АХБ-ны төсөл 12.0 тэрбум	Хөгжлийн төвтэй болсон аймаг, дүүрэг /тоо/	6	-	8	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд тус яамнаас Баянзүрх дүүрэг, Завхан аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, 2026 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Завхан аймагт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 04 дүгээр сард зарлан 7 байгууллага материал ирүүлж, шалгараагүй тул 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр дахин зарласан бөгөөд 06 дугаар сарын 12-ны өдөр нээж, үнэлгээг хийнэ. Баянзүрх дүүрэгт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын зураг төсөвт магадлал хийлгэхээр Барилгын хөгжлийн төвд хянуулахаар хүргүүлсэн. Өмнөговь аймагт орон нутгийн төсвөөр барьсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг ХБХХЕГ-ын харьяанд шилжүүлэх саналыг боловсруулан Засгийн газрын 2025 оны 212 дугаар тогтоолоор батлуулсан.	Х/б
4.4	Арга хэмжээ 4.4. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн	үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагаа явуулах төв /тоо/	4	-	10	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг улсын хэмжээнд санхүүжүүлэн ажиллуулахад 2025 оны улсын төсөвт 8,9 тэрбум төгрөгийг тусгасан.	100

	хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулна.						<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28.1 дэхь заалт, Боловсролын тухай хуулийн 17.9 дэхь заалтуудын хүрээнд Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/85, А/55, А/49 хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм”-ийг баталсан.</p> <p>Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/64 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн үйлчилгээний аргачлал заавар, үнэ тариф”-ыг баталсан.</p> <p>Үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран зохион байгуулж, Баянхонгор аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Реха сентер, Энэрэлийн түүчээ, Энх гэр бүл, Эрхэм нандин сувд, Аутимэд хийсэн аялал, Ээлтэй Ертөнц төрийн бус байгууллага гэсэн 7 байгууллага шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.</p>	
4.5	Арга хэмжээ 4.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын холбогдох дүрэм, журмыг шинэчилнэ.	үйл ажиллагааны зардал	Засгийн газрын тогтоол /тоо/;	0	-	1	<p>Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, салбар комиссын гишүүдэд 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Ирүүлсэн саналыг дүрмийн төсөлд тусгаж байна.</p> <p>Энэ оны 4-6 дугаар сард зохион байгуулсан ХБХЭМБНХ-ын салбар комиссын сургалтын үеэр дүрмийн төслийг оролцогчдоор хэлэлцүүлж, санал авах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх цогц үйлчилгээний удирдамж болон комиссын дүрэмд ICF-ийг тусган чиглэлээр зөвлөх үйлчилгээний удирдамжийн төслийг боловсруулж байна.</p>	70
<b>Зорилт 5: Хүүхдийн хөгжил, хамгаалал, хүн амын бүлгүүдийн цогц хөгжил, оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах</b>								

5.1	Арга хэмжээ 5.1. Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан шинээр ажиллуулж, чиглүүлэх, мэргэшүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна. /ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.7/	Улсын төсөв 138.4 сая.төг	Сум, хороо бүрд ажиллах нийт нийгмийн ажилтан /тоо/	0	534	833	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36-р зүйлийн 36.6-д Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг анхан шатны нэгжид ажиллуулах зохицуулалт хуульчлагдсаны дагуу Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал", 2 дугаар хавсралтаар "Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо"-г нийслэлд 268, орон нутагт 565, нийт 833 албан хаагч ажиллахаар батласан. 2025 оны 05-р сарын 31-ний өдрийн байдлаар 700 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг сонгон шалгаруулж, ажилд томилон, мэргэжлийн удирдлагаар ханган, ажиллаж байна. 2025 оны 2-р хагас жилд ЗГ-аас тогтоосон орон тоогоор ажиллах бүрэн боломжтой.	100
			Зохион байгуулсан мэргэшүүлэх сургалт /тоо/	0	2	3	1.Шинээр томилодсон нийгмийн ажилтныг "Чадавхжуулах-мэргэшүүлэх" сургалтын хэрэгцээнд зориулж "Нийгмийн ажлын кэйс менежмент"-ийн сургалтын хөтөлбөр, гарын авлага, хүүхэд хамгааллын үйлчилгээний маягт, аргачлал, зааврыг боловсруулж, хэвлүүлсэн. 2.Үндэсний сургагч багшийн сургалт хийж, 40 сургагч багш бэлтгэсэн. Сургагч багшийг бэлтгэх сургалтыг Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран Их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, нийслэл, дүүргийн Нийгмийн ажилтны төлөөллөөс бүрдсэн баг 5 хоногийн хугацаанд хамтран зохион байгуулж, шаардлага хангасан 40 оролцогчид "Чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтын сургагч багш"-ийн гэрчилгээ олгосон.	
							1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/32 дугаар тушаалаар "Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм"-ийг шинээр батласан. 2.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах удирдамжийг боловсруулж, зарлалыг	X/6

5.2	Арга хэмжээ 5.2. Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлнэ.		Ёс зүйн хорооны тоо	0	30	30	яам, агентлагийн цахим хуудсаар дамжуулан <a href="https://mlsp.gov.mn/content/detail/3676">https://mlsp.gov.mn/content/detail/3676</a> холбоосоор 4-р сарын 25-наас 5-р сарын 25-ны өдрийг дуустал нээлттэй зохион байгуулсан. Ирүүлсэн 17 хүсэлтийг судлан, хэлэлцэж, 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Үндэсний хороог байгуулах урьдчилсан уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтыг 6-р сарын 9-ны өдөр хийхээр төлөвлөсөн. Уг арга хэмжээг 3,4 дүгээр улиралд зохион байгуулна.	
5.3	Арга хэмжээ 5.3. "Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага", "Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний стандарт"-ын хэрэгжилтийг хангуулна.	Улсын төсөв	Зохион байгуулсан хяналт, шалгалтын тоо	0	0	2	Сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөсөн. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны ёс зүйн хороодыг 4-8 дугаар сард байгуулж, хорооны гишүүдэд хүүхэд, гэр бүлийн салбарт мөрдөж буй дүрэм, журам, стандартыг танилцуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар мэргэжил, арга зүйн чиглэл өгч, сургалт хийх бөгөөд 8-11 дүгээр сард стандартын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийхээр төлөвлөсөн болно.	X/6
5.4	Арга хэмжээ 5.4. Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг сурталчлан таниулна.	Улсын төсөв 90.0 сая	Сургалтад хамрагдсан хүн /тоо/	7100	273	7300	Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, 15 зурагт постор, 6 видео боловсруулж, олон нийтэд түгээсэн. Мөн эхний хагас жилийн байдлаар батлагдсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлж мөрдөх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын албан хаагч 243 хүн, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 30 сурагчид сургалт зохион байгуулсан. Хэвлэл мэдээллийн ярилцлага 8, подкаст-1 зэргээр олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг хийж ажилласан.	90
5.5	Арга хэмжээ 5.5. Хүүхэд хамгааллын кейс менежмент, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд хүргэнэ.	Улсын төсөв 10.6 тэрбум	Хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлт /хувь/	69.3 хувь	65 хувь	75 хувь	2025 оны хагас жилийн байдлаар 6784 эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд илрүүлж, нөхцөл байдлыг үнэлэн, кейс нээж ажилласан. 2025 оны хагас жилийн байдлаар 57,8%-тай байна.	90

	/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.5/							
5.6	Арга хэмжээ 5.6. Төрийн байгууллага, аж ахуйн нэгжид “Хүүхэд хамгааллын бодлого” мөрдүүлнэ. /ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.5/	Улсын төсөв 80.0 сая	Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын эзлэх хувь Баталсан акт /тоо/ Сургагч багш /тоо/	3.7 хувь 0 0	25 хувь 1 0	25 хувь 1 100	Улсын хэмжээнд 4579 байгууллага, аж ахуй нэгж Хүүхэд хамгааллын бодлого баталж, 10053 байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулагдаж, 1014 байгууллага хүүхдийн ерөө тохижуулж, 103 байгууллага дэргэдээ хүүхдийн цэцэрлэг байгуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн. Хүүхэд хамгааллын тухай хуультай /Шинэчилсэн найруулга/ нийцүүлэн “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг шинэчлэн боловсруулж байна.	70
5.7	Арга хэмжээ 5.7. Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг таниулахаар ерөнхий боловсролын дунд сургуулийн сурагчдад шүүх хуралдааны танхимд сургалтыг сар бүр явуулна.	Үйл ажиллагааны зардал	Сургалтад хамрагдсан хүүхэд /тоо/	0	30	180	Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, 15 зурагт постор, 6 видео боловсруулж, олон нийтэд түгээсэн. Мөн эхний хагас жилийн байдлаар батлагдсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлж мөрдөх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын албан хаагч 243 хүн, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 30 сурагчид сургалт зохион байгуулсан. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 8 ярилцлага, 1 подкастыг зохион байгуулж, Хүүхэд хамгааллын тухай хууль, эрх зүйн баримт бичгүүдийн талаар олон нийтэд хандсан мэдээлэл сургалт, сурталчилгааг хийсэн.	100
5.8	5.8. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллыг сайжруулна.  5.8.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.	Үйл ажиллагааны зардал	Батлагдсан журам /тоо/ Бэлтгэгдсэн мэргэжилтэн /тоо/ Арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьсан талаарх тайлан /тоо/	0 0 0	 10 1	1 10 1	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасны дагуу “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам”-ын төсөл боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар байгуулж, баримт бичгийн шинжилгээ хийгдэж, журмын төслийг боловсруулах ажлыг эхлүүлсэн.  2/ Аймаг, дүүрэг, сум дундын шүүхтэй суманд 38 Хүүхдийн эрхийн хууль шинэчлэгдэн байгуулагдаж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40-43 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 3/ Архангай, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Орхон, Говьсүмбэр аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавжуулах сургалт зохион байгуулагдаж, 110	90

	<p>5.8.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулна.</p> <p>5.8.3.Хууль зүйн хорооны шийдвэр, үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн сантай танилцан, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавина.</p>						<p>гишүүн, хорооны ажлын алба хамрагдаж, чадавхжсан.</p>		
5.9	<p>Арга хэмжээ 5.9. "Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцох журам", Нөхцөл байдлын үнэлгээний журмыг шинэчлэн батлуулна.</p>	-	Батлуулсан баримт бичиг /тоо/	0	1	1	<p>Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцох журмын төслийг боловсруулсан, батлуулахаар дотооддоо санал авч байна.</p>	70	
<b>Зорилт 6: Эрүүл насжилтыг дэмжих</b>									
6.1	<p>Арга хэмжээ 6.1. Ахмадын хөгжлийн 3 төвөөр дамжуулан идэвхтэй насжилтыг дэмжих загварыг нэвтрүүлнэ. /Алсын хараа 2050-3.1.13, ЗГҮАХ 2.1.1.18/</p>	АХБ-ны төсөл 3.0 сая ам доллар	Үйлчилгээний загвар төв /тоо/	0	1	3	<p>Азийн хөгжлийн банктэй хамтран Олон нийтийн оролцоонд түшиглсэн ахмад настны урт хугацааны шинэлэг тогтолцоог хөгжүүлэх нь төслийн Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн загварыг бий болгосон. Ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ахмад настны цогц үнэлгээ хийж, үнэлгээнд суурилан хэрэгцээ, шаардлагтай тусламж, үйлчилгээг цогц байдлаар хүргэх, ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих болон асаргааны хувилбарт үйлчилгээг хүргэх зохицуулалт шинээр</p>	70	

							тусгагдсан. Хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Идэвхтэй насжилтын төвүүдээр шинээр гаргасан загварыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.	
<b>Зорилт 7: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах</b>								
7.1	Арга хэмжээ 7.1.Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх багц сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана: /ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.24/	Улсын төсөв 100.0 сая.төг	Төлөвлөгөө /тоо/	-	1	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан аяны хүрээнд 15 постер, контентийг олон нийтэд түгээж, хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай хамтран ажиллаж байна.	90
			Сургалт /тоо/	10	10	30	Мөн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх нөлөөллийн сургалтыг дараах байгууллага, албан хаагчдад зохион байгуулсан. Үүнд: - Нийслэлийн 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн нийт 91 албан хаагчдад цахимаар; - Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн 40 албан хаагчдад танхимаар; - Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хэсгийн ахлагч нийт 44 хүнд танхимаар;  - ГБХНХ-ын Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/82 дугаар тушаал, ХБХХЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/46 дугаар тушаал, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/73 дугаар тушаалын дагуу төвийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Хөвсгөл аймгийн ХБХХТ-ийн 29 албан хаагчдад, 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Дундговь аймгийн ХБХХТ-ийн 29 албан хаагчдад танхимаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулсан.	
			Контент /тоо/	-	-	20	Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр олон улсын тэмдэглэлт өдрүүдийг угтаж хөгжлийн бэрхшээл хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлснээр тухайн хүүхдэд хугацаа алдахгүйгээр хөгжлийн дэмжлэг үзүүлэх, мөн хоёрдогч хүндрэлээс сэргийлэх талаар постер, мэдээлэл бэлтгэн яамны пэйж хуудсанд байршуулж байна.	

							<p>Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд “Түгээмэл хөгжил” ТББ-тай хамтран ГБХНХЯ-ны барилгын гадна болон дотор орчны байдалд хүртээмжийн үнэлгээг хийсэн. Нийт 135 асуумжийн хүрээнд үнэлэхэд 42.2% нь хүртээмжгүй үнэлэгдсэн байна. Иймд үнэлгээнээс гарсан тайлан, зөвлөмжийн дагуу сайжруулах арга хэмжээг төлөвлөж байна.</p> <p>Нийтийн тээврийн бодлогын газар, “Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-той хамтран 2025 оны 05 дугаар сард нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа зарим автобусны хүртээмжийн байдалд үнэлгээ хийсэн. Тус үнэлгээг “Нийтийн тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2021, “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага UCS 1603B:2022 стандартыг баримтлан 15 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн. Үнэлгээнээс гарсан тайлан, санал зөвлөмжийг албан бичгээр Нийтийн тээврийн бодлогын газарт хүргүүлсэн.</p> <p>“Түгээмэл хөгжил” ТББ-тай хамтран “MONGOLIA TRY - 2025” нөлөөллийн арга хэмжээг 06 дугаар сарын 13-ний өдрөөс 24-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Тус ажлын хүрээнд ТНБД-ийн “Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах тухай” тушаалын төслийг батлуулсан ба удирдамж, хөдөө орон нутагт ажиллах төсвийн тооцоо болон хөтөлбөр, ажил гүйцэтгэх гэрээг тус тус гарган баталгаажууллаа. Мөн аймаг болон НЗДТГ-т хамтран ажиллах албан бичгийг хүргүүлээд байна.</p> <p>Мэдээллийн хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд “Зайнаас зөвлөн туслах төв”-ийн 1800-0724 тусгай дугаараар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх, яам, салбарын үйл ажиллагааг сонголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор дохионы хэлмэрч орчуулагч нартай гэрээ байгуулан ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар</p>	
7.2	<p>Арга хэмжээ 7.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хангаж, мэдээллийн болон дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.24/</p>	Улсын төсөв 250.0 сая.төг	Үнэлгээний тоо	0	-	20		90

							<p>дохионы хэлмэрч орчуулагчид дараах үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Зайнаас зөвлөн туслах төвд хандсан нийт 1202 хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлсэн;</li> <li>-Шүүхийн шийдвэр болон цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд 8 удаагийн дохионы хэлмэрчийн үйлчилгээ үзүүлсэн;</li> <li>-1 контент;</li> <li>-14 удаагийн сургалт зөвлөгөөнд дохионы хэлмэрч орчуулагч;</li> </ul> <p>Дохионы хэлний анхан шатны сургалт 2 удаа зохион байгуулсан байна.</p>	
7.3	<p>Арга хэмжээ 7.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн санг байгуулах</p>	<p>үйл ажиллагааны зардал</p>	<p>Мэдээллийн сан /тоо/</p>	-	-	1	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах ажлыг ҮСХ-той хамтран зохион байгуулж байна. Энэ хүрээнд мэдээллийн сангийн программыг боловсруулах мэргэжилтний ажлын даалгаврыг боловсруулсан.</p> <p>Ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, мэдээллийн сангийн статистикийн бүртгэлийн маягтыг шинээр, захиргааны 30 маягтыг шинэчлэн боловсруулан яамны газар, хэлтэс болон харьяа агентлагуудаас санал авах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>- Хөдөлмөр эрхлэх сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэл, судалгааны ажилтай уялдуулан НДЕГ, ХХҮЕГ-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийг авч тулган, суурь санг байгуулаад байна.</p>	70
7.4	<p>Арга хэмжээ 7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах</p>	<p>Улс, орон нутгийн төсөв, АХБ-ны төсөл</p>	<p>Төлөвлөгөө /тоо/</p>	-	1	-	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/48 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн төлөвлөгөө”-г 43 арга хэмжээтэй хэрэгжүүлэхээр баталсан. Төлөвлөгөөг харьяа агентлаг, газар хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнахаар ажиллаж байна. Мөн жилийн хүрээнд салбар дундын уялдааг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн, тэдний онцлог, хэрэгцээ, ур чадварт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэх, иргэд, ажил олгогчдын ойлголт, хандлагыг сайжруулах, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад</p>	70

			Хэрэгжилтийн хувь	-	40	80	холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/82 дугаар тушаалаар 6 бүсэд зохион байгуулахаар баталсан. 2025 оны 06 дугаар сарын байдлаар Хөвсгөл, Дундговь аймгуудад бүсийн цогц арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилийн байдлаар 40 хувьтай байна.	
<b>Нийт 7 зорилт, 29 арга хэмжээ, Үүнээс: 100%-4, 90%-13, 70%-7, х/б-5</b>								<b>86.0</b>

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн дарга  
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн шууд захирагч



/Л.МӨНХЗУЛ/


(гарын үсэг)

(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга  
(албан тушаал)

Нэгжийн дарга



/Д.Ренчиндорж/

(гарын үсэг)

(огноо)

Тайлагнасан:

Гэр бүлийн бодлогын газрын дарга  
(албан тушаал)

Нэгжийн дарга



/Ц.Мөнхзул/

(гарын үсэг)

(огноо)

ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.МӨНХЗУЛЫН 2025 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,  
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

Нэгжийн нэр: Гэр бүлийн бодлогын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	86.0	60

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1. <i>Барууны нэг үүргийн хүртэл зохсон байгууллагад сургалт, татварын орлого.</i>	90.	13
2.	Арга хэмжээ 2. <i>Барууны нэг үүргийн сургалт, туршлага сургалт амжилт.</i>	90.	13
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			13

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
-----	----------	--

1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	15
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	15
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	15
<b>Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо</b>		<b>15</b>

#### 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо <b>60.0</b>
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо <b>13</b>
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо <b>15</b>
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	..... оноо
<b>Нийт оноо =</b> ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		<b>88.0</b>

**Үнэлгээ өгсөн:**

Төрийн нарийн бичгийн дарга  
(албан тушаал)

**Төсвийн шууд захирагч**

*[Signature]* /Ц.МӨНХЗУЛ/  
(гарын үсэг) (албан хаагчийн нэр)

ATA12944 9132155 9024070603

..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:**

Гэр бүлийн бодлогын газрын дарга

(албан тушаал)

**Нэгжийн дарга:**

*[Signature]*

(гарын үсэг)

/Ц.МӨНХЗУЛ/

(албан хаагчийн нэр)

..... (огноо)